



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ар Ус Ундарга ОНӨХХК-ний 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2023/01/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn
Архангай аймаг
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Ахлах аудитор Н.Алтантуяа
Утас: 7033-3019
Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АР УС УНДАРГА ОРОН НУТГИЙН
ӨМЧИТ ХХК- НИЙ ЗАХИРАЛ
С.БААТАРХУЯГ ТАНАА

2023.03.15 № 131
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ар Ус Ундарга ОНӨХХК-ний 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Ар Ус Ундарга ОНӨХХК-ний 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулга Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Тайлант жилд тус хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага 3 удаа солигдсон байна.
- Хуулийн этгээдийн удирдлага болон нягтлан бодогч нар нь 188,039.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг ажлаас чөлөөлөгдсөн хугацаанд цахим банкаар дамжуулан хийсэн нь хуурамч тамга тэмдэг үйлдэн ашигласан байж болзошгүйг нягтлуулахаар хууль хяналтын байгууллагад шилжин шалгагдаж эцэслэн шийдвэрлэгдээгүй.
- Компаний санхүүгийн тайлан дахь 38,781.6 мянган төгрөгийн авлага нь тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй хууль хяналтын байгууллагаар шалгагдаж байна.
- Тайлант оны авлагын үлдэгдлээс 7,832.5 мянган төгрөг нь тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй, бизнес төлөвлөгөөнд батлагдаагүй зардал гаргасан, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулахад шилжүүлсэн 6600.0 мянган төгрөгийг авлагаар бүртгээгүй, баримт бичгийг хүлээн аваагүй.
- Зочин төлөөлөгч хүлээн авах, сургалт семинарын зардалд нийт 6,100.0 мянган төгрөгийг захирлын тушаалаар хоол, зочид буудлын төлбөр, бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуулиудыг зөрчсөн, бидний тооцсон материаллаг байдлын

түвшнээс дээгүүр, аудитын тохиолдсон байх, эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	426,832,259.51	319,106,158.68
1.1.02	Дансны авлага	101,878,541.02	21,611,650.49
1.1.04	Бусад авлага	4,680,000.00	35,420,036.89
1.1.06	Бараа материал	194,317,513.57	162,210,693.83
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,589,138.00	315,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	732,297,452.10	538,663,539.89
1.2.01	Үндсэн хөрөнгө	1,192,626,532.76	1,149,723,089.44
1.2.02	Биет бус хөрөнгө	3,395,610,000.00	3,402,960,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,588,236,532.76	4,552,683,089.44
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,320,533,984.86	5,091,346,629.33
2.1.1.01	Дансны өглөг	111,281,388.94	187,951,720.60
2.1.1.03	Татварын өр	3,981,446.34	18,957,545.47
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	4,511,813.59	289,420.86
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	2,140,887.60	1,277,381.27
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	121,915,536.47	208,476,068.20
2.1.2.01	Урт хугацаат зээл	2,229,007,293.10	1,767,000,000.00
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	299,093,630.48	299,950,339.10
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,528,100,923.58	2,066,950,339.10
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,650,016,460.05	2,275,426,407.30
2.3.01	Өмч: - төрийн	351,271,342.52	351,271,342.52
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	206,573,729.30	206,573,729.30
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	3,395,610,000.00	3,395,610,000.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-1,282,937,547.01	-1,137,522,849.79
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-310,478,936.86
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-1,282,937,547.01	-827,043,912.93
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,670,517,524.81	2,815,932,222.03
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,320,533,984.86	5,091,358,629.33

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	1,325,184,993.80	1,226,878,702.22
02	Борлуулалтын өртөг	1,236,209,221.15	1,370,360,476.52
03	Нийт ашиг(алдагдал)	88,975,772.65	-143,481,774.30
05	Хүүний орлого	76,969,282.86	8,460,105.66
06	Түрээсийн орлого	989,200.00	-
08	Бусад орлого	1,200,000.00	64,112,836.37
08.1	Орлогын дүн	79,158,482.86	72,572,942.03
10	Ерөнхий ба удирдлагын зардал	183,015,465.60	162,920,797.13
12.1	Зардлын дүн	183,015,465.60	162,920,797.13
17	Бусад ашиг (алдагдал)	49,275,097.35	-71,253,307.46

Ар Ус Ундарга ОНӨХХК-ний 2022 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

17.1	Олз, гарзын дүн	49,275,097.35	-71,253,307.46
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-64,156,307.44	305,082,936.86
19	Орлогын татварын зардал	7,696,928.14	5,408,000.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-71,853,235.58	-310,490,936.86
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-71,853,235.58	-310,490,936.86
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,821,300,772.20	1,555,873,519.38
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,821,300,772.20	1,555,873,519.38
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,798,793,513.26	1,580,366,176.87
1.2.1	Ажиллагчдад төлсөн	510,574,959.50	621,783,337.89
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	124,674,625.19	172,628,708.43
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	13,728,879.85	234,043,182.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	276,695,901.25	245,356,646.48
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	9,098,170.00	73,220,106.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	33,592,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	174,992,671.99	97,343,723.73
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	1,489,550.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	689,028,305.48	100,908,922.34
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	22,507,258.94	-24,492,657.49
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	8,472,305.66
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.00	8,472,305.66
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	80,432,459.03	91,705,749.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	80,432,459.03	81,805,749.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	9,900,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-80,432,459.03	-83,233,443.34
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-57,925,200.09	-107,714,100.86
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	484,757,459.60	426,832,259.51
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	426,832,259.51	319,118,158.65

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2020 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	351,271,342.52	206,573,729.30	3,395,610,000.00	- 1,282,937,547.01	2,670,517,524.81
09	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	351,271,342.52	206,573,729.30	3,395,610,000.00	- 1,282,937,547.01	2,670,517,524.81
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	455,893,634.08	455,893,634.08
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-310,478,936.86	-310,478,936.86
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	2022 оны 12 сарын 31-р үлдэгдэл	351,271,342.52	206,573,729.30	3,395,610,000.00	- 1,137,522,849.79	2,815,932,222.03

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Тайлангийн жилд тус хуулийн этгээдийн захирал 3-н удаа солигдсон бөгөөд өмнөх удирдлага нягтлан бодогч нартай холбоотой санхүүгийн дараах асуудлууд хууль хяналтын байгууллагад шилжин хянагдаж, эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. Үүнд:

- Аймгийн засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 11-ний Б/09 дүгээр захирамжаар Ар Ус Ундарга ОНӨХХК-ний захирал Б.Булганчимэгийг захирлын үүрэгт ажлаас чөлөөлж, мөн өдрийн Б/10 дугаар захирамжаар Ч.Түвшинтөгсийг тус хуулийн этгээдийн захирлаар томилжээ. Ар Ус Ундарга ОНӨХХК-ний захирлын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 01 дүгээр тушаалаар нягтлан бодогч Б.Ганчимэгийг ажлаас нь чөлөөлсөн байна.

Компаний удирдлагын зүгээс Захирал асан Б.Булганчимэг, нягтлан бодогчоор ажиллаж байсан Б. Ганчимэг нар нь ажлаас чөлөөлөгдсөн шийдвэр гарснаас хойш буюу 2022 оны 02 дугаар сарын 11-ээс 04 дүгээр сарын 13-ны өдрийг хүртэлх хугацаанд цахим болон арилжааны банкаар 188,039.4 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийснийг хуурамч тамга тэмдэг үйлдэн ашигласан байж болзошгүй гэж үзэн хууль хяналтын байгууллагаар шалгуулж байгаа бөгөөд эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.

- Санхүүгийн тайлангийн авлагын дансанд бүртгэлтэй дараах авлагууд нь тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй, хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлэгдээгүй байна. Үүнд:
 - Захирал асан Б.Булганчимэгээс 4,357.1 мянган төгрөг, өмнөх нягтлан бодогч Б.Ганчимэгээс 7,310.5 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа, албан томилолт бусад зардалтай холбоотой тооцоо
 - Амгалан завилгаа ХХК-нд давсны үнэ 6,600.0 мянган төгрөгийг шилжүүлсэн
 - Иргэн Д.Чинбаатарт 38,664.0 мянган төгрөгийн нүүрсний үнийг шилжүүлж 18,150.0 мянган төгрөгийн нүүрсийг хүлээн авч бүртгэлд тусган, 20,514.0 мянган төгрөгийн авлагын тооцоотой байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар 50,711.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрч санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ. Үүнд:

- Орлогын тайланд гэрээгээр ажил гүйцэтгэсэнтэй холбоотой бусад орлого болон борлуулсан бүтээгдэхүүний өртгийг 36,054.3 мянган төгрөгөөр бууруулах бичилт хийснийг санхүүгийн тайланд залрууллаа.
- Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн зардлыг 14,657.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг бараа материал худалдан авахад төлсөн зардалд тусгуулан залрууллаа.

Аудитаар залруулагдаагүй нийт 27,565.5 мянган төгрөгийн зөрчил² илэрч, 568.0 мянган төгрөгт 1 төлбөрийн акт, 26,997.5 мянган төгрөгт 4 албан шаардлага хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

5.1 Албан томилолтын зардлыг 4 албан хаагчид нийт 568.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна. Энэ нь 2019 оны Засгийн газрын 06 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.4-т "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно" гэж заасныг зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох

3.2 Албан шаардлага

5.2.1. Тайлант онд үүссэн 2 ААН-ийн 5440.9 мянган төгрөг, 2 албан хаагчийн 815.0 мянган төгрөг, өмнөх оноос шилжиж ирсэн 2 албан хаагчийн 950.0 мянган төгрөг, 2 төсөвт байгууллагын 626.6 мянган төгрөгийн нийт 7832.5 мянган төгрөгийн авлагын бүртгэл нь тооцоо нийлсэн актаар баталгаажуулагдаж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.2.2. Тайлангийн жилд 6465,000 төгрөгийн албан томилолтын зардал гаргасан нь бизнес төлөвлөгөөнд батлагдаагүй байна. Энэ нь Ар Ус Ундарга ХХК-ний ТУЗ-ийн 2022 оны 06 дугаар сарын 22-ны 03 дугаар тогтоолоор баталсан "Компаний 2022 оны бизнес төлөвлөгөөг батлах тухай" тогтоолын 1-д заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.2.3. Ар Ус Ундарга ОНӨХХК-ний захирлаар ажиллаж байсан Б.Булганчимэг нь 2022 оны 01 дүгээр сарын 12-нд Ворлдвайд файнанс аудит ХХК-тай/ РД:5470501/ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, 2022 оны 01 дүгээр сарын 10-ны дотор хийж гүйцэтгүүлэн хүлээн авахаар 6,600.0 мянган төгрөгийг шилжүүлсэн бөгөөд НББ-ийн бодлогын баримт бичгийг хүлээн авч данс бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.2.4. Тайлант онд зочин төлөөлөгч хүлээн авах, сургалт семинарын зардалд нийт 6100,000 мянган төгрөгийг захирлын тушаалаар хоол, зочид буудлын төлбөр, бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 04 дүгээр зүйлийн 4.2.1-д "Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15.1.5-т "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.2.3-т "Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

.....ооо.....

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ар Ус Ундарга ОНӨХХК	2	50711.8			2	50711.8	1	50711.8	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/ Үүнээс		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ар Ус Ундарга ОНӨХХК	5	27565.5	1	568.0	4	26997.5	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/ Үүнээс				
							Зөвлөмж				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
Ар Ус Ундарга ОНӨХХК	1	0	0	0	1	0	0	0	0	0	0